



Л.Буянжаргал
ХААИС-ийн БУС-ийн Компьютерийн тэнхимийн багш, магистр

БАГШ АЖЛЫН БАЙРАНДАА ХӨГЖИХӨД ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

Abstract: Teacher development has been influenced by many factors. However, the most positive impact is the school environment, because it is the first place to develop them. The basis of teacher development in their working place is their collegiality, and activities implemented by the school administration.

Key words: teacher development, convenient facilities, creative colleagues, cooperation

Оршил

Манай улс боловсролын системдээ өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас судалж, түүний дэвшилттэй болон өөрийн орны нөхцөлд тохирохыг нь туршин хэрэгжүүлж байгаа энэ цаг үед сургуулийг шинэчлэн боловсронгуй болгон хөгжүүлэх, үйл ажиллагааных нь үр дүнг дээшлүүлэх, чанартай сургалт явуулах зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нэн түрүүнд багшийг хөгжүүлэх зорилт хурцаар тавигдаж, багш хөгжих бүхий л бололцоотой, оновчтой ажлуудыг бодлогын хэмжээнд хэрэгжүүлж байна. Нөгөө талаас боловсролын шинэчлэлийн хөгжилд багш өөрөө хөгжих нөхцөл бололцоог удирдлагын болон үйл ажиллагааны шат бүрд төлөвлөгөөтэйгөөр зохицуулан зохион байгуулах нь багшийн үүрэг билээ.

Багшийн ажлын гол үзүүлэлт нь чанартай сургалт байдаг. Иймээс чанартай сургалт явуулахын тулд багш хөгжих хэрэгтэй. Хөгжихийн тулд:

- Мэдлэгийн эрин зуунд шинэ мэдээлэл, технологийг хүлээн авч ашиглах,
- Тулгамдсан асуудалд судалгаа хийж, үр дүнгээ хэрэгжүүлэх
- Сурах, сургах үйл явцыг зөв жолоодох,
- Мэдлэг чадвартай харилцааны өндөр соёлтой хамтран ажиллах арга ухааныг эзэмшсэн байх асуудал чухлаар тавигдаж байна.

Судалгааны хэсэг

Багш ажлын байрандаа хөгжихийн гол үндэс тулгамдсан асуудал нь юу болох талаар :

1. Мэдлэг боловсролын түвшин
2. Мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс
3. Сурган хүмүүжүүлэх авьяас чадвар, арга барилын талаарх цогц ойлголт
4. Байгууллагын үүр амьсгал
5. Хөгжих арга замыг тодорхойлох судалгаа авлаа


Багш ажлын байрандаа хөгжих хандлагын талаар судалгааг нээлттэй асуулгын, түүврийн аргаар авлаа. Судалгаанд ХААИС-ийн математик, гадаад хэл, мал эмнэлэг, биотехнологич, хүнсний технологич агрономич, архитектор, газар зохион байгуулалт, инженер, экологи зэрэг мэргэжлийн нийт 60 гаруй багш хамрагдлаа.

1-р асуулт. Багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, багшийг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс юу болохыг тодорхойлно уу гэсэн асуултад дараах байдлаар хариулсан байна.



Хүснэгт 1

№	Хариулт	Тоо	Хувь
1	Онолын мэдлэг	26	43,3%
2	Заах арга, ур чадвар	36	60%
3	Сурах сургах арга барил	28	46,6%
4	Судалгаа хийх чадвар	16	26,6%
5	Харилцаа ёс зүй	46	76,6%
6	Өөрийн идэвх, бүтээлч ажиллагаа	32	53,3%
7	Мэдээлэл харилцааны технологи эзэмшилт	34	56,6%
8	Хамтын бүтээлч үйл ажиллагаа	44	73,3%
9	Сургалтын орчин	56	93,3%
10	Удирдлагын дэмжлэг	52	86,6%
11	Багшийг хөгжүүлэх бодлого	24	40%



Эндээс харахад, багш нарын хувьд удирдлагын зөв бодлогын хүрээнд сургалтын **таатай орчинд** тогтвортой ажиллаж, хамтын бүтээлч үйл ажиллагааны үндсэн дээр өөрийн идэвх, заах арга бариллаа сайжруулан орчин үеийн хөгжлөөс хоцрохгүй байх ёс зүйг эрхэмлэх хэрэгцээ давамгайлж байна.



Иймээс багшийн хөгжлийг дэмжих гол хүчин зүйл нь хөгжих **таатай орчин** бөгөөд таатай орчныг бүрдүүлэх хүчин зүйл нь **бүтээлч хамт олон**, хамт олныг бүрдүүлэх хүчин зүйл нь **хамтын үйл ажиллагаа** юм.

Эдгээр үзүүлэлт нь багшийн ажлын байрандаа хөгжихөд хамтын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх хүчин зүйл учраас харилцан хамааралтай авч үзэх хэрэгтэй.

А. Багш хөгжинө гэдэг нь өмнө таньж мэдэж байсан зүйлдээ түшиглэн шинэ үр дүн, арга зам олж давуу сайныг бий болгохын нэр байдаг. Бүтээлч үйлс шинэчлэх, өөрчлөх гэсэн хоёр гол хэмжүүрээр тодорхойлогддог.

Б. Таатай орчин нь багшийг хөгжүүлэх үндэс суурь болох тул сургуулийн удирдлагын болон хамт олны дэмжлэг туслалцаа чухал байр эзэлнэ.

В. Бүтээлч хамт олон нь багшийн хөгжлийг дэмжинэ. Хөгжих чадвартай гар сэтгэл нийлсэн бүтээлч хамт олныг төлөвшүүлэх нь багшийн хөгжлийг дэмжих таатай орчныг бүрдүүлэх гол хүчин зүйл болох бөгөөд сургуулийн удирдлага, хамт олон, багш бүхэн энэ орчныг бүрдүүлэхэд санаачилгатай

ажиллах шаардлагатай. Бүтээлч хамт олныг бүрдүүлж чадсан байгууллага дээр багш хөгжинө, энэ орчныг бүрдүүлж чадсан сургуульд багшийн хөгжил тасралтгүй байна.

Г. Бүтээлч хамт олны хамтын үйл ажиллагаа нь багшийг хөгжүүлэхэд оршино. Хүчин зүйл нь харилцан бие биеэ ойлголцох, шударга шүүмжлэл, илэн далангүй яриа, харилцан итгэлцэх итгэлцэл бий болох нь ажлын амжилтын үндэс болно.

“Хүн харилцан идэвхтэй туршлага солилцох бүрд өөрчлөгдөж, амьдралын турш тасралтгүй хөгжиж байдаг” гэдэг эртний Хятадын Күнзийн сургаалд хэлсэн байдгаас үзэхэд сурган хүмүүжүүлэх ажлын нэг онцлог бол хамтын ажлын үр дүн юм.


Багшийг хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд саланги тусгай арга барилаар бус харин цогц арга барил шаардлагатай. Үүнд:

2-р асуулт: Багшийн сурган хүмүүжүүлэх ямар авьяас чадвар, ямар арга барилуудыг цогц гэж үзэх вэ гэдэг асуулгаар 30 багшаас түүвэрчилсэн судалгааг авахад дараах байдлаар хариулсан байна.

Хүснэгт 2

№	Хариулт	Тоо	хувь
1	Ажлыг үр бүтээлтэй зохион байгуулах чадвар	18	60%
2	Харилцааны чадвар	25	83,3%
3	Танин мэдэхүйн чадвар	14	46,6%
4	Ажиглалт судалгаа хийх чадвар	11	36,6%
5	Анхаарал, эв дүй	27	90%
6	Өөрийн ажлын үр дүн болон бэрхшээлийг урьдчилан тооцох чадвар	13	43,3%

График 1



Эндээс үзэхэд, багшийн ажлын эв дүй, харилцааны урлаг, ажлыг зохион байгуулах чадвар хүн бүрд байх боловч сурган хүмүүжүүлэх авьяас чадварын хөгжлийн амжилтаас шалтгаалан багш нарыг:

- Мэргэжлийг түргэн эзэмшиж, саатал тасалдалгүй явсаар ажиллах өндөр үр чадварт хурдан хүрдэг.
- Алгуур удаан, заримдаа сааталд ордог боловч сурган хүмүүжүүлэх үр чадварыг эзэмшдэг.
- Хэдийгээр олон жил ажилласан боловч өндөр үр чадвар эзэмшиж чадаагүй гэсэн 3 бүлэгт хамааруулж болох юм.

Иймээс багш нар судалгаа шинжилгээ хийх, гарын авлага, ном бичих интернэт ашиглан цаг үе, дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагаар өөрийгөө хөгжүүлэх шаардлага нийгмийн хөгжлийг даган гарч ирж байгааг анхаарах цаг болжээ.

3-р асуулт: Байгууллагын дотоод уур амьсгал нь бүтээлч хамт олныг бий болгох хөшүүрэг болох тул багш нараас бие биедээ хандах хандлага, хүсэл сонирхол, үнэлэмж баримжааллыг тогтоох зорилгоор дотоод уур амьсгалын судалгааг авлаа.

Асуулгын аргаар ХААИС-ийн 54 багшаас авсан 15 асуулт бүхий энэ судалгаанд оролцогчдын насны




бүтэц:

Хүснэгт 3

35 хүртэлх насны	36-50 хүртэлх насны	50-аас дээш насны
62,5%	25%	12,5%

График 3



Хүйсийн байдал: эмэгтэй-87,5%, эрэгтэй-12,5%

Ажилласан жил: 1-5 жил 55%, 5-12 жил 30% буюу ихэнх нь залуу багш нар хамрагдлаа.

Судалгааг дараах 15 асуулгаар:

- Ажлын байрандаа өөрийгөө хөгжүүлэх нөхцөл бололцоо хэр хангагдсан байдаг вэ?
а. маш сайн б. сайн с. дунд д. муу
- Хамт олон бие биетэйгээ элэгсэг дотно харьцдаг, сэтгэл санаа өөдрөг, харилцан нөлөөлж чаддаг уу.
- Бусад сургууль, тэнхимүүдийн багш нартай харилцан ойлголцож, хамтран ажилладаг уу.
- Хамт олон хамтын үйл ажиллагаанд оролцох, чөлөөт цагаа өнгөрүүлэх, ажиллах боломжтой юу.
- Нөхдийн амжилт азгүйдэл аль алиныг хуваалцдаг, бүгд нэгдмэл санаатай, бие биедээ туслахыг хичээдэг үү.
- Бие биеийнхээ хүсэл сонирхолд хүндэтгэлтэй ханддаг уу.
- Бэрхшээл хүндрэлтэй үед “Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгний төлөө” зарчимтай ажиллаж чаддаг уу.
- Хамт олноороо бахархдаг уу.
- Хамт олон идэвх санаачилгатай эрч хүч ихтэй байдаг уу.
- Хамт олон шинэ гишүүнд хүндэтгэлтэй хандаж, тэдний дунд дасаж нөхөрлөхөд нь тусалдаг уу.
- Хамт олонтойгоо хамтарч ажиллах дуртай. Энэ үед урам зоригтой ихийг амжуулж чаддаг уу.
- Хамт олны гишүүн бүр тэгш эрхтэй, хоцронгуй, сул нэгэндээ байнгын анхаарал тавьж тусалж дэмжиж ажиллаж чаддаг уу.
- Хамт олны гишүүнийг удирдлагын зүгээс урамшуулан тэмдэглэхэд түүгээр бахархах сэтгэл байнга төрдөг үү.
- Сургуулийн зүгээс багш нарын дунд тэднийг хөгжүүлэх олон ажил зохиож чаддаг уу.
- Удирдлагын зүгээс хамт олныгоо байнга ойлгож, тусалж, дэмжлэг үзүүлж байдагт хамт олон талархдаг уу.

Хүснэгт 4: Хариултыг нэгтгэхэд:

Асуулт Хариу	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	Тоо	Хувь
маш сайн	2	6	4	8	4	8	3	10	5	7	3	1	0	2	0	63	7.78%
сайн	11	22	23	20	27	18	28	25	16	28	21	16	18	28	14	315	38.9%
дунд	38	23	23	20	21	22	21	18	25	16	23	25	31	20	30	356	44%
муу	3	3	4	6	2	6	2	1	8	3	7	12	5	4	10	76	9.38%
Нийт	54	54	54	54	54	54	54	54	54	54	54	54	54	54	54	810	100%

Эндээс харахад, идэвх санаачилга, эрч хүч, өөрсдөөрөө бахархах сэтгэл бие биедээ харилцан нөлөөлөх нөлөөлөл сайн боловч хамт олныхоо дутагдлыг хуваалцахдаа учир дутагдалтай, бэрхшээл хүндрэл тохиолдоход нэгдэж ажиллах зарчим баримталж чаддаггүй, удирдлагын зүгээс хамт олныгоо ойлгож, төдийлөн тусалж дэмждэггүй юм байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

Судалгаанд оролцсон хамт олны сэтгэл зүйн уур амьсгал буюу байгууллага, хамт олондоо хандах хандлага ерөнхийдөө уур амьсгал тийм ч хангалттай сайн биш, харин байгаа орчин, нөхцөл байдалдаа дасал болсон байдал ажиглагдлаа. Бас сөрөг хариултаас төдийлөн сонголт хийгээгүй байгаа нь сөрөг уур амьсгал харьцангуй бага харагдаж байгаа нь талархмаар үр дүн байна.


Иймээс “Хамтын бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэхийн тулд удирдлагын зүгээс хамт олны гишүүдийг ойлгон дэмжих, бие биеийнхээ алдаа дутагдлыг засан залруулж, байнга тусалж дэмжих аваас бүтээлч хамт олон бүрдэж, багшийн хөгжилд нөлөөлөх ахиц гарах болно” гэж дүгнэлээ.

Асуулт 4: Ажлын байрандаа хөгжих арга замыг тодорхой болгохын тулд дараах судалгааг авлаа. Сургуулийн зүгээс ямар арга хэмжээг зохион байгуулбал үр дүнд хүрэх вэ гэсэн асуулгад 30 багш дараах байдлаар хариулсан байна.

Хүснэгт 5

№	Хариулт	тоо	хувь
1	Багшийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	26	86,6%
2	Техник технологийн хүртээмжийг сайжруулах	22	73,3%
3	Мэдээлэл технологийн хэрэглээг сайжруулах	25	50%
4	Туршлага судлах, солилцох	11	36,6%
5	Бүх багш нарыг хамарсан сургалт, секц явуулах	1	40%
6	Сэтгэл зүйн болон бүтээлч орчныг бүрдүүлэх	28	93,3%
7	Багш нарын амжилтыг сурталчлах, урамшуулах	26	86,6%
8	Багшийн хөгжилд түлхэц өгөх, хянах, дүгнэх	24	80%

График 2



Эндээс харахад, сургууль өөрийн нөөц боломждоо тулгуурлан техник технологийн хүртээмжийг дээшлүүлэх, мэдээлэл технологийн хэрэглээг сайжруулах, сэтгэл зүйн орчныг бүрдүүлж чадвал багш хурдан хөгжих боломжтой.

Хэрхэн хөгжүүлэх вэ?

Багш хүн нийгмийн хөгжлийн чиг хандлагыг урьдчилан харж сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа хэтийн төлөвтэй хоорондын уялдаа холбоотойгоор явуулж үр дүнд хүрч байх ёстой бөгөөд багшийн хөгжлийн үйл явц, үр дүн нь багш бүрийн хамтын бүтээлч үйл ажиллагаанаас шууд хамааралтай. Тийм учраас багш бүр дараах чадварт суралцан тасралтгүй хөгжиж байх чухал.

- Судалгаа хийх чадварыг сайжруулах /багш бүр судалгаа хийх арга зүйг эзэмших, тогтмолжуулж чанаржуулах/
- Мэдлэг чадварыг дээшлүүлэх /мэргэжлийн болон сурган, сэтгэл зүйн хандлагыг өөрчлөх/
- Харилцааны чадварыг сайжруулах /бүтээлчээр хамтран ажиллах, бие биеэсээ суралцах уур



амьсгал бүрдүүлэх/

- Манлайлах чадварыг хөгжүүлэх /бусдадаа үлгэрлэх, зорилгодоо хүрэх чин эрмэлзэлтэй байх/
 - Орчин бүрдүүлэх /хөгжлийн бодлого боловсруулж, ажиллах нөхцөл бололцоог хангаж өгөх/
- Эдгээр чадварыг багш бүр эзэмшихийн тулд үйл ажиллагаа бүтээлч хамт олныг бүрдүүлэх, өөрөө түүний нэг хэсэг нь байж хувь нэмрээ оруулах нь чухал юм.

Хамтын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх арга зам

Ер нь багш хөгжихгүйгээр боловсролд шинэчлэл явагдах боломжгүй. Багш хөгжсөнөөр сургууль хөгжиж улмаар боловсролын хөгжил, нийгмийн хөгжилд хувь нэмэр болно.

Багш сурган хүмүүжүүлэгчдийг боловсролын шинэчлэлийн өнөөгийн шаардлагад нийцсэн сайн багш болгох, хөгжлийг нь дэмжих гол хүчин зүйл бол тэдний тасралтгүй сурч хөгжих **хөгжингүй орчныг бүрдүүлэх** явдал юм.

Мөн дэлхийн улс орнуудын нийтлэг жишгийн дагуу багшийн хөгжлийн талаар үзэл баримтлалыг шинэчилж багш ажлын байрандаа хөгжих тогтолцоо бодлогыг боловсруулах, сургууль багш нар мэдээллийг тогтмол шуурхай авах мэдээлэл технологийн найдвартай сүлжээ бий болгох хэрэгтэй байна.

Санал

- Сургуульд түшиглэсэн нөөц бололцоог нэмэгдүүлэх, багш хөгжлийн төв байгуулах, боловсронгуй болгох
- Бүтээлч багш нарын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжих,
- Сургуулийн удирдлага бүтээлч хамт олныг төлөвшүүлэх тал дээр санаачилгатай ажиллах
- Багш нарын мэдээлэл технологийн хэрэглээ, боломжийг сурталчлах, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах хэрэгтэй.

Дүгнэлт

Багш ажлын байрандаа хөгжихөд олон хүчин зүйлс чухал болох нь ажиглагдаж байна. Үүнд:

- Сургууль өөрийн нөөц бололцоог ашиглан ажлын байранд дахь сургалтыг төлөвлөх, чанартай гарын авлага, ном, сурах бичгээр хангах
- Багшийг ажлын байранд хөгжүүлэх арга зүй болон мэдээлэл технологийн боломж, давуу талыг нээлттэйгээр хангаж өгөх
- Багшийн хөгжил, сургуулийн шинэчлэл хамт олны хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлэх арга механизмыг боловсронгуй болгох
- Багшийг үндсэн ажлын хүрээнд тасралтгүй хөгжих ажлыг зохион байгуулах
- Багш нар харилцан мэдээлэл солилцох, сургалт, семинар, секц зохион байгуулах нь ажлын байран дээр бие даан тасралтгүй хөгжих боломжийг бий болгоно гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Багшийг хөгжүүлдэг, мэргэжил дээшлүүлдэг сургалтыг зохион байгуулдаг улс орнуудын туршлагаас.

(2005 *Нээлттэй сургууль сонин*)

Батхуяг, С. Боловсролын стандарт ба сургууль багшийн хөгжил

Жадамбаа, Н. *Багш нарыг хөгжүүлэх тухай зарим асуудал*

Исмаил, Бозв (2005). *Анги удирдах урлаг*. Улаанбаатар

Очирбат, П., ба бус. (2005). *Тогтвортой хөгжлийн боловсрол*. Улаанбаатар

Оюун, Ц. (2003). *Багшийн хөгжлийн зарим асуудалд*. Улаанбаатар

Санжаабадам, С. (2003, № 45). Боловсрол нь хүнийн хөгжлийн гол хүчин зүйл мөн. *Нээлттэй сургууль сонин*

Цэгмэд, Р., Мөнхжаргал, Д. (2006). *Боловсролын шинэчлэлийн асуудлууд*. Улаанбаатар

Эрдэнэжаргал, П., Жадамбаа, Б., Энхтуяа, Н. Сургуульд суурилсан боловсролын шинэчлэл